# ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ
# 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 11 дугаар сарын 29

| № | Заалт | Хэрэгжилт |
|---|---|---|
| Нэг: Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн | | |
| 1. | Монгол улсын тогтвортой хөгжил үзэл баримтлал-2030"-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл | **Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, Оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэт арга аргачлалыг нэвтрүүлсэн, нэр төрлийг нь нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажлууд:**<br>Эрүүл мэндийн төвд 2021 онд Улсын төсвөөс 39 нэр төрлийн 1.591.171.440 төгрөгийн багаж, тоног төхөөрөмж, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 18 нэр төрлийн 179.835.700 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжүүд /4D ЭХО аппарат, Биохимийн бүрэн автомат анализатор, Зөөврийн дижитал рентген, Дижитал рентген аппарат, Зөөврийн ЭХО аппарат, Амьсгалын аппарат, Ходоодны дурангийн аппарат, Холтер, ЗЦБ, ЗАЦБ, Нүд, чих хамар хоолойн иж бүрэн аппарат,Хүчилтөрөгч өтгөрүүлэгч, Хяналтын монитор, Иж бүрэн компьютер/, НЭМГ-аас дархлаажуулалтын хүйтэн хэлхээнд зориулж ЭМТөв болон ӨЭМТүүдэд 116 ширхэг хөлдөөгч, хөргөгч, вакцины хүйтэн сав, вакцин зөөврлөх савыг тус тус нийлүүлсэн. Мөн Медстар Эрдэнэ ХХК-аас 6 нэр төрлийн 46.724.400 төгрөгийн чих хамар хоолойн дурангийн үзлэгийн иж бүрдэл, УЗН-ээс Хүчилтөрөгч өтгөрүүлэгч, Хяналтын монитор зэрэг тоног төхөөрөмжийг хандивласан.<br>Эрүүл мэндийн төвийн " Б " корпусын 500 м2 талбайд 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар их засвар, 865 сая төгрөгийн үнэ бүхий 11 нэр төрлийн тоног төхөөрөмжийг суурилуулж, "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг байгуулсан.<br><br>Угтах үйлчилгээ: |





2021 оны 8,9 дүгээр сард сургууль цэцэрлэгийн багш, ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт 10 сургууль,11 цэцэрлэг, хувийн 2 цэцэрлэг, Этүгэн их сургуулийн нийт 1879 багш, ажилчдыг цээжний рентген, сүрьеэгийн үзлэгт хамруулж, үүнээс сүрьеэгийн 2 тохиолдлыг илрүүлж эмчилгээнд хамруулсан.





2021 оны 02 дугаар сард яармаг салбар амбулаторид молекул биологийн лабораторийг нээж ДЭМБ, АШУИС, УКНЭ –ийн лабораторийн мэргэжилтнүүдээс арга зүйн зөвлөмж авч тоног төхөөрөмжийг суурилуулсан. Лабораторийн мэргэшсэн 12 хүний бүрэлдэхүүнтэй 3-н ээлжээр 24 цагт 800 сорьцонд шинжилгээ хийх нөхцөл бүрдсэн.

2021 оны эхний 11 сарын 25-ны байдлаар нийт 96833 сорьц хүлээн авч шинжилгээ хийж 11699 эерэг тохиолдлыг илрүүлэн мэдээлсэн байна.





| | | |
|---|---|---|
| | | Коронавируст  халдвар /COVID-19/-ын өвчлөл нэмэгдсэнтэй холбогдуулан ЭМЯ-ны шийдвэрээр Туул-100 ортой тусгаарлах эмнэлгийг 2021 оны 06 дугаар сараас нээн ажиллуулж 2021 оны 06 дугаар сараас 11 дүгээр сарын 25-ны хооронд нийт 1536 хүнийг хэвтүүлэн эмчилсэн.<br>  <br>Эрүүл мэндийн төв нь 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр “Тайваний хүүхэд гэр бүлийг дэмжих сан ”-гаас 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар  “Шүдний гажиг заслын кабинет”-ийг  Нийслэлийн хэмжээнд анх удаа нээж дүүргийн иргэдэд шүдний гажиг заслын эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх бүрэн боломжтой болсон. |

<table>
<tr><td></td><td></td><td>
Нийслэлийн Эрүүл мэндийн газраас жил бүр зохион байгуулагддаг сайн туршлага шалгаруулах “Сайн туршлага 2021” арга хэмжээнд шүдний их эмч Г.Төрбат оролцож, “Хан-Уул дүүргийн хүн амд эрүү нүүрний гажиг заслын тусламж үйлчилгээг үзүүлэх нь” бүтээлээрээ тусгай байрын шагнал хүртсэн.<br>









<br>
Сонсголын бичлэг хийх иж бүрэн тоног төхөөрөмж болон өрөөг тохижуулан ажиллаж байна.
</td></tr>
</table>



Яармаг салбар амбулаторид жирэмсний нэг цэгийн үйлчилгээг тохижуулсан.



Яармаг салбар амбулаторид Мэс заслын кабинетад засвар хийсэн.



Коронавирусын /COVID-19/- ын халдварын тархалыг бууруулах үйл ажиллагааны хүрээнд Эрүүл мэндийн төвийн 56 баг, нэмэлт 8 багт, ПОС төхөөрөмж 84, бусад эрүүл мэндийн байгууллагын 72 ПОС буюу Хан-Уул дүүргийн хэмжээнд 156 ПОС төхөөрөмжийг сервис үйлчилгээ, тохиргоо тест, автоматжуулах ажлыг нийслэлийн хэмжээнд анх удаа хийсэн.

Нэг хаалга – Нэг шинжилгээ үйл ажиллагаанд ПОС төхөөрөмж ашиглан сорьцын бүртгэл хийж дайчлагдан ажиллах, дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын багш нарыг бэлтгэх ажлыг боловсролын хэлтэстэй хамтран зохион байгуулж 83 багшийг бүртгэгч ажилтнаар 2021 оны 02 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд сургасан.





Коронавирүсийн батлагдсан тохиолдол ихтэй 4х,10х,11х, 15х,16х,19х, 20х хороонд “Ковид -19 амбулатори”-ийг 09 сарын 25-аас үе шаттай нээж ажиллуулж байна Коронавирусын халдвараар өвчлөөд эдгэрсний дараах хяналтын рентген шинжилгээг хороо бүрээр хувиар гаргана ЭМТ-ийн дэмжих төвийн рентгений кабинетад цээж рентгенд харах ажлыг зохион байгуулан одоогийн байдлаар 8 хорооны 557 хүнийг рентгенд харж зөвлөгөө өгөөд байна Яармаг салбар амбулаторийн дэргэд ковидын амбулаторийг нээн рентген аппарат шинээр суурилуулан сургалт хийгдлээ

Хан-Уул дүүрэгт ковид-19 халдварын эсрэг шуурхай хариу арга хэмжээний 16 баг, тандалтын 4 баг 24 цагаар эмнэлзүйн тандалт, хариу арга хэмжээг авч тусламж үйлчилгээг үзүүлэн, хавьталын шинжилгээнд хамруулан, зөвлөгөө өгч ажиллаж байна. 2021 оны 4-8 сард 41-р сургууль дээр 24 цагаар байрлан үйл ажиллагаагаа явуулсан. 2021 оны 9-р сараас





Мотобуудлагын спортын төвд шилжин ажиллаж байна. Өдөрт 13 баг, 32 төрийн албан алба хаагч, эмч нар ажиллаж байна. Үүнд:

- Өдрийн 10 баг - Эмнэлзүйн 6 баг, тандалт 4 баг,
- Шөнийн 3 баг – Эмнэлзүйн шуурхай дуудлага
- 24 цагийн 3 оператор – Яаралтай дуудлага, заавар зөвлөгөө, мэдээлэл
- ШХАХ баг ажилласнаар иргэддээ зөвлөгөө өгөх, эрэмбэлэн ангилж эмнэлэг рүү зөөвөрлөх, яаралтай дуудлаганд шуурхай тусламж үзүүлэх зэрэг Ковид-19 цар тахалтай холбоотой бүхий л үйл ажиллагаанд оролцон үүрэг гүйцэтгэж байна

11.20-ний байдлаар хяналт.

| Нийт батлагдсан тохиолдол | Нас баралт | | Эдгэрсэн | Эмчлэгдэж байгаа | | | Ойрын хавьтал |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сүүлийн 24 цагт | Нийт | | эмнэлэгт | Гэрт | Нийт | |
| 66910 | 0 | 124 | 59916 буюу 89,5% | 1936 | 4531 | 6446 | 5916 |

Одоогийг байдлаар батлагдсан 4531 иргэн гэрээр эмчлэгдэж 21 ӨЭМТ-ийн 32 эмч хянаж байна .

| | | |
|---|---|---|
| | |     **Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.** |

- ЭМС-ын 2018 оны А/546, А/611 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор ӨЭМТ-ийн нярай, бага насны хүүхдийн гэрийн эргэлтэд дэмжлэгт хяналт хийж эмч нарт ажлын байранд зөвлөгөө өгч ажилласан.





- ЭХЭМҮТ, ЭМЯ, ЭМХТ, АШУҮИС, ХӨСҮТ, ЭМТ-өөс “Шинэчилсэн ХӨЦМ-ийг сэргээх, батжуулах, хүүхдийн яаралтай тусламж, эрэмбэлэн ангилалтаар ӨЭМТ-үүд *“ Шинэ коронавирусын халдварын хүүхдэд тохиолдох хэлбэр,түүний ангилал, эмнэл зүй, эмчилгээ, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, яаралтай үед авах арга хэмжээ*” сэдэвт цахим болон ажлын байран дахь нийт 7 удаагийн сургалтанд ЭМТ, 21 ӨЭМТ-ийн нийт 152 эмч хамрагдсан.
- 08 дугаар сарын 31 нд сургууль,цэцэрлэгийн 45 эмчид “ Хүүхдийн /COVID-19/ халдварын эмнэл зүй оношилгоо, эмчилгээ, хүүхдээс түргэвчилсэн тестээр шинжилгээ авах арга зүй дадлага сургалт зохион байгуулсан.
- 16 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүүхдийн тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийж 92 эмч, сувилагч нарт




мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.
- “Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж, “ Амилуулах суурь тусламж ”-ийн сэдэвт сургалтуудад ӨЭМТөвөөс нийт 51 эмч хамрагдсан.
- Эрүүл мэндийн төвийн хүүхдийн эмч, өсвөр үеийн эмч нарыг “Хүүхдэд тохиолдох COVID- 19-ын халдварын үеийн оношилгоо эмчилгээ”сэдэвт 2 удаагийн танхимийн сургалтанд хамруулсан.

- 2021 оны эхний хагас жилийн хүүхдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус эндэгдлийн 22 тохиолдлын эмнэл зүй, эмгэг судлалын хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, зөвлөмжийг гарган ажиллалаа.
- Хүүхдийн 2 кабинет, ЭМТ-ийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний бэлэн байдалд дэмжлэгт хяналт хийж /яаралтай эм, тариа, хувийн хамгаалах хэрэгсэл/-ийн бэлэн байдлын нөөц заавар зөвлөмжийг өгсөн.
- 16 өрхийн эрүүл мэндийн төв болон Эрүүл мэндийн төвд 24 цагийн зөвлөгөө өгөх утсыг ажиллуулж 15000 нь иргэдэд зөвлөгөө өгсөн байна

| № | Эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, тун хэмжээ | Хэмжих нэгж /ш/ | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага | Хорогдол | Эцсийн үлдэгдэл /нөөц / | Иргэдэд олгосон тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | жирэмслэлтээс хамгаалах эм | Хайрцаг | 8059 | 0 | 8059 | 0 | 0 | 8059 |
| 2 | Суулгац | ширхэг | 10 | 0 | 10 | 0 | 0 | 0 |
| 3 | Тариа | ширхэг | 4528 | 0 | 410 | 0 | 4118 | 410 |
| 4 | Ерөндөг | ширхэг | 194 | 0 | 194 | 0 | 0 | 194 |
| 5 | Охидын ерөндөг | ширхэг | 2 | 0 | 2 | 0 | 2 | 2 |
| 6 | Яаралтай уух хэрэглэх эм | Хайрцаг | 155 | 0 | 46 | 0 | 109 | 46 |
| 7 | Бэлгэвч | ширхэг | 13484 | 0 | 13484 | 0 | 0 | 13484 |
| 8 | Тест | ширхэг | 125 | 0 | 125 | 0 | 0 | 125 |
| 10 | Тариур 5,0 | ширхэг | 78 | 0 | 4 | 0 | 0 | 78 |

- Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж буй Цахим эмч 119 дугаартай холбох Coll- pro үйлчилгээг 341003 дугаар дээр холбож үйлчилгээг нээсэн. Үүнд: Хүүхдийн зөвлөгөө өгөх 345903 дугаарын утас, хүүхдийн их эмч Ц.Ариунаа 99201202, 342257 утсанд тархвар судлаач нар, 21 ӨЭМТөвүүд иргэдэд 24 цагаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллаж байна.
- Байгууллагын вэб хуудсаар болон цахим хаягаар иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмжийг тогтмол хүргэж иргэдийн хандалт 17500 болсон.

| | | |
|---|---|---|
| | | ❖ Эх барих эмэгтэйчүүдийн кабинетаас “Эрүүл ээж - Эрүүл удам “ facebook групп нээж жирэмсэн эхчүүдэд эрүүл мэндийн зөвлөмжийг тогмтол өгч ажиллуулж байна<br>❖ Хан-уул дүүрэгт ЭМТ болон 21 ӨЭМТ-ийн хяналтад нөхөн үржихүйн насны 59156 эмэгтэйчүүдийг жирэмсэнээс хамгаалах арга хэрэгсэлээр тогтмол хангаж ,эрсдэлт бүлгийн эхчүүдийг илүүтэй анхаарал ажиллаж байна. Мөн эдгээр насны эмэгтэйчүүдийг сургалт, сурталчилгаа, мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.<br>❖ Эх нярайн мэдээг www.hinfo.mnсайтад өрхийн эрүүл мэндийн төв бүрт эрх нээн өгч мэдээллийг цаг алдалгүй авч эргэн мэдээллэж байна. Мөн хэвтэж эмчлүүлсэн, ЯТТ-д үзүүлсэн хүүхдийн мэдээллийг цахим хэлбэрээр авч гэрийн эргэлтийг хийж байна.<br><br>Эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах<br>❖ Ковид-19 цар тахалтай холбоотой “Эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах”-ыг таниулах, эрүүл хооллолтыг сурталчилах ажлыг дүүргийн хэмжээнд цахим хэлбэрээр хийж гүйцэтгэж байна. Үүнд:“Эрүүл зөв зохистой хооллолт” “Хүүхдийн хоол тэжээл”, “хүнсний аюулгүй байдал”, “Хүүхдийн хоол тэжээлийн доройтол”, “Хүүхдийн өвчин эмгэгүүд” ,”Эхийн сүүгээр хооллох ач тус” “Нэмэгдэл хоол өгөх зааварчилгаа”сэдэвт цахим видео хичээлд 5926 иргэн хандалттай байна. Хүүхдийн зохицуулагч эмч “Нялх, бага насны хүүхдийн хүнсний тухай хууль” болон “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхамыг хэрэгжүүлэх заавар” танилцуулах ажлуудыг цахимаар ӨЭМТ-үүдийн 110 эмч ажилчдад хийсэн<br>❖ Зорилтот бүлгийн 1200 хүүхдэд витаминжуулалт болон хүүхдийн бичил тэжээл олгох үйл ажиллагааг ӨЭМТ-ээр дамжуулан 6-59 сартай 30360 хүүхдэд өндөр тунт А амин дэмийг өгсөн. Мөн 0-5 насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд “А аминдэмээр баялаг хүнс хэрэглэж хүүхдийнхээ нүдний хараа, мэдрэлийн үйл ажиллагаа, дархлааг дэмжин, арьс салстыг хамгаалах, өсөлт, хөгжил”-ийн талаарх зөвлөмжийг 2062 ширхэгийг тараасан.<br>  |

- ❖ ЭМТөв болон ӨЭМТөвүүдийн цахим хуудсанд “Хүүхдийг эхийн сүүгээр хооллохын ач холбогдол” талаарх зөвлөмжийг байршуулж 8014 иргэнд дараах сэдвүүдээр зөвлөгөө, мэдээлэл өгч, 249 иргэнд гарын авлага тараан ажиллалаа. Үүнд:
- ❖ Эхийн сүүний ач холбогдол
- ❖ Хөхөөр хооллохын давуу тал
- ❖ Тэжээвэр хооллолтын сул тал
- ❖ Эхийн сүүгээр хооллох нь эх, үр хоёрт яагаад чухал байдаг тухай
- ❖ Энхрий үрс эрүүл торниход Эцэг хүний дэмжлэг яагаад чухал байдаг вэ?

**Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.**

- ❖ Халдварт бус өвчний анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах чиглэлээр нийт 21 хорооны ӨЭМТ-үүд болон ЭМТөв нь 409 удаагийн сургалт, 3 өдөрлөг зохион байгуулж давхардсан тоогоор 17390 иргэн, цахим сургалт сурталчилгаанд 56267 иргэнийг хамруулж 48465 ширхэг тараах материал түгээсэн ба цаг үеийн мэдээлэл, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр байгууллагын цахим хуудас, Facebook хаягаар хүргүүлж ажилласан.





- ❖ **2021 оны эхний 10сарын байдлаар:** Дүүргийн зорилтот бүлгийн 118527хүн амаас АГ-ын эрт илрүүлэг үзлэгт 74325 хүн хамрагдаж 62,7%-тай байна.
Үүнээс: эрэгтэй -32502, эмэгтэй 41823
АГ- шинээр оношлогдсон 52 хүнийг эмчийн хяналтанд авч, давтан үзлэгт 13562 хүн орж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.

Чихрийн шижин хэв шинж -2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа 60381 хүн хамрагдаж 50,9 %-тай байна. Үүнээс: эрэгтэй -26627, эмэгтэй -33754, шинээр оношлогдсон 6 хүнийг эмчийн хяналтанд авч, давтан үзлэгт 4376 хүн орсон байна.

- Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт нийт 10380 эмэгтэй хамрагдахаас эхний 11 сарын байдлаар 2642 эмэгтэй хамрагдаж 25 %-тай хамрагдсан байна.
- Хөхний хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт 46519 эмэгтэй хамрагдахаас эхний 11 сарын байдлаар 28469 эмэгтэй хамрагдаж 61% -тай байна.
- Мобайл технологийг 2016 онд 12-р хорооны өрхийн эмнэлэгт нэвтрүүлэн ажиллаж байна. 2021 онд Эрүүл мэндийн сайдын дэмжлэгтэйгээр 12 өрхийн эмнэлэг мобайл технологийн зүрхний бичлгэйин аппарат, таблетаар хангагдсан. Мобайл технологийн зүрхний бичлэгийн аппаратаар 13120 хүнд зүрхний бичлэг хийж үзлэг оношилгоонд хамруулсан байна.
- “Ковид-19” цар тахалтай холбоотойгоор сургалтуудыг цахим хэлбэрээр явуулж 317 удаагийн сургалтаар ХУЭМТ, ӨЭМТ-үүд цахим хуудсанд зурагт хуудас, бичлэг байршуулснаар 56267 удаагийн үзэлт, хандалтыг авсан байна.
- ЭМТ болон 21 ӨЭМТ-ийн хяналтад нөхөн үржихүйн насны 59156 эмэгтэйчүүдийг жирэмсэнээс хамгаалах арга хэрэгсэлээр тогтмол хангаж ,эрсдэлт бүлгийн эхчүүдийг илүүтэй анхаарал ажиллаж байна. Мөн эдгээр насны эмэгтэйчүүдийг сургалт, сурталчилгаа, мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.
- Хүсээгүй жирэмслэлт, аюултай үр хөндөлтөөс сэргийлэх зорилгоор ХУЭМТ ийн эх барих эмэгтэйчүүдийн кабинет үйлчлүүлэгчдэд зориулж ”Ерөндөг тавих тухай” жирэмслэх сэргийлэх арга хэрэгсэлийн тухай “ сэдэвт мэдээлэл бэлтгэж байгууллагын вэб сайт болон фейсбүүк хуудсаар болон танилцуулга хэлбэрээр бэлдэж гаргасан. Үйлчлүүлэгчдэд зориулж “Хүсээгүй жирэмслэлт, аюултай үр хөндөлтөөс сэргийлэх талаар мэдээлэл бэлтгэн өөрсдийн мэдээллийн самбар дээрээ тавьсан.






- Эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх бүлгийн хүрээнд ЭМТ, ӨЭМТ-үүд холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран 28 удаагийн өдөрлөг, аян, 2 удаагийн болзолт уралдаан 33 удаагийн тэмдэглэлт өдөрт 551 удаагийн танхим болон цахим сургалтад 297 төрлийн гарлын авлга, тараах материал, 141 төрдийн зурагт хуудас, 76985 ширхэг тараах материалыг ард иргэдэд түгээж, 163215 иргэнд эрүүл мэндийн боловсролыг олгож ажилласан байна. ХУЭМТ болон ӨЭМТ-үүд харьяа нутаг дэвсгэрийн ААН байгуулагуудтай

| | | |
|---|---|---|
| | | хамтран ажиллаж эрүүл мэндийн боловсрол олгох, тэднээр дамжуулан бусад салбар болон ажлын хамт олон хувь хүмүүст нөлөөлүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах зэрэгт татан оролцуулж ажиллаж байна.<br>❖ Ажилаас халширах хам шинжийн судалгааг эрүүл мэндийн төвийн 46 эмч, 42 сувилагч, 20 бусад ажилтан нийт 106 эмч, ажилчдаас авч дүгнэсэн. Судалгааны үр дүнд ажилчдын сэтгэл хөдлөл буурах үзүүлэлт 16.03%, сэтгэлээр мэдрэх чадвар буурах үзүүлэлт 32% , бүтээмж буурах үзүүлэлт 29.2%-ийн өндөр үзүүлэлттэй байна. Судалгаанаас харахад ажлын бүтээмж буурах, сэтгэлээр мэдрэх чадвар буурах үзүүлэлт эмч, сувилагч нарын дунд өндөр гарч байгаа тул ажилчдын дунд сэтгэл зүйн сургалт, сурталчилгаа, эерэг уур амьсгал бүрдүүлэх ажил үе шаттайгаар зохион байгуулах хэрэгцээ шаардлагатай байгааг харуулж байсан.<br>❖ "Сэтгэл зүйн дархлааг дэмжих" аяны хүрээнд 4 удаагийн сэтгэл зүйн сургалтыг 106 ажилтанд, дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэх зорилгоор 1 сарын турш бүжгийн сургалтыг багштайгаар хичээлүүлж байна.<br><br>**Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.**<br>Монгол Улсын Засгийн газрын "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 91 дүгээр тогтоол, Улсын Онцгой Комиссын "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/265 дугаар, Эрүүл мэндийн төвийн даргын "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээг дахин зохион байгуулах тухай" А/31 дүгээр тушаал, "Коронавируст халдвар /Ковид-19/ ын тандалт шуурхай хариу арга хэмжээг зохион байгуулах тухай" А/32 дугаар тушаалууд гарч дараах зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.<br><br>❖ Эмнэлгийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж чиглэлээр 2020 оны 11 сарын 13-аас Бямба, Ням гарагт эмч нарыг 10-16 цагийн хооронд ажиллуулсанаар эрүүл мэндийн төвийн амбулатори болон өрхийн эрүүл мэндийн төвүүдээр нийт 34452 хүн үйлчлүүлж тусламж үйлчилгээ авсан.<br>❖ "Коронавирусын халдварын хяналт, сэргийлэлт, бэлэн байдал, дэгдэлтийн үед ажиллах хариу арга хэмжээг эрчимжүүлэх" тухай ЭМТөвийн даргын А/03 тоот, "Гамшгаас хамгаалах албаны штабын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай" А/18 тоот, "Коронавируст халдвар /Ковид-19/ ын тандалт шуурхай хариу арга хэмжээг зохион байгуулах тухай" А/32 тоот тушаал, 18 заавар журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>❖ Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 104 дугаар тушаалын хэрэгжилийг хангаж "Коронавируст халдварын цар тахлын хариу арга хэмжээ"-ний явцын үнэлгээг дараах үндсэн 4 чиглэлээр хийсэн.<br>❖ Удирдлага, төлөвлөлт, зохицуулалт |

- Мэдээлэл харилцаа, тандалт хяналт
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, халдварын сэргийлэлт хяналт
- Нөөц, хангамж, санхүү, хяналт
- Тусламж үйлчилгээний үед халдварын сэжигтэй болон баталагдсан тохиолдол илэрсэн үед хөдөлгөөний зохицуулалтыг зохион байгуулах зураглалыг Амбулатори, Хэвтэн эмчлүүлэх тасаг, Хүлээн авах яаралтай тусламжийн тасаг гэсэн чиглэлүүдээр 1-4 давхарт хэн хэн ямар үүрэг гүйцэтгэж ажиллах чиглэлээр зураглалыг гаргаж батлуулан эмч ажилчдад танилцуулан гарын үсэг зуруулж баталгаажуулан ажилласан.






- Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, ор дэлгэх төлөвлөгөөний дагуу 7 орыг бэлтгэсэн, 215 нэр төрлийн эм тариа, 89 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 237 тоног төхөөрөмжийн судалгааг гарган ажилласан.





- ❖ Тусгаарлах өрөөг 2 ортойгоор  стандарт шаардлагын дагуу урсгалыг зохион байгуулан бүс бүрт байх шаардлагатай багаж тоног төхөөрөмж хэрэгслүүдийг тус тусд нь байршуулж бэлэн байдлыг ханган ажиллаж нийт 102 сэжигтэй тохиолдлыг тусгаарлан онош батлагдсан.63 тохиолдлыг зөөвөрлөн тусгаарлуулж эмчлүүлсэн.





- ❖ Хэвтэн  эмчлүүлэх тасгийн тусгаарлах болон, Туул 100 тусгаарлах эмнэлгийн улаан, шар бүсүүдэд  камер байршуулж,тусламж үйлчилгээ, халдвар хамгааллын дэглэм, хамгаалах хувцас хэрэгслийг зөв тайлж байгаа эсэхэд тухай бүр нь  ЭЭО даргын өрөөнөөс хянан  ажиллаа.






Хөтөчийн ажиллах зааврыг боловсруулж халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний заавар зураглал, зайлшгүй шаардлагатай утаснуудын жагсаалтууды гарын авлага болгож өдөр тутам арга зүйгээр ханган ажиллаж байна.

Амбулаторийн нэг даврхын үүдний хэсгийн зохион байгуулалтыг өөрчилж зай талбайг томсгон хөтөч үйлчлүүлэгчдийн халууныг үзэх, асуумж авах , QR кодыг уншуулахыг зөвлөн, хөдөлгөөний зохицуулалтыг хийж ажиллаж байна. Байгууллагынхаа QR кодыг хэвлэн амбулатори, хүлээн авах хэсэгийн орох хаалганы дэргэд байршуулсан.






“Ковид 19” халдвартай өвчтөнийг эрт илрүүлэх зорилгоор амьсгалын замын өвчний шинж тэмдэгтэй өвчтөний үзлэгийн өрөөг 1 давхарт зохион байгуулан ажиллуулж байна. Ажиллах эмч нарын хуваарийг гаргаж батлуулж тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

| | | |
|---|---|---|
| | |  <br><br>Хэвтэн эмчлүүлэх тасаг , хүлээн авах яаралтай тусламжийн тасгийн болон хариу арга хэмжээний 3 багийн нийт 32 эмч эмнэлгийн ажилтнуудад хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх тайлах дадлага сургалтыг 3 удаа хийж шалгуур хуудсаар 2 удаа үнэлэхэд 82,4%-иас 86,6% болж өмнөх түвшнээсээ 4,2%-иар ахисан байна.<br><br>   |

| | | |
|---|---|---|
| | | Эмч ажилчдид, хэвтэн эмчлүүлэгчдийн дунд “COVID-19” илрүүлэх тандалтыг ЭМТ-ийн төвийн бүх эмч,эмнэлгийн ажилтнуудыг хамруулан PCR шинжилгээнд , 2021.01.05 –нд 163 хүнийг –хамруулсан ба 1-р сарын 14-өөс эхлэн 7 хоног бүр бүх ажилчдын 30%-ийг хамруулж байхаал хуваарь гарган нийт 7удаагийн шинжилгээнд бүх эмч ажилчдыг 100% хамруулж ажилласан ЭМС-ын 2021 оны 329 тоот тушаалын дагуу эмч эмнэлгийн ажилтнуудыг коронавируст халдварын илрүүлэг шинжилгээнд хамруулах хуваарийг гаргаж нийт 12 удаагийн тандалтын шинжилгээнд давхардсан тоогоор 526 эмч эмнэлгийн ажилтнуудыг хамруулахад 56 тохиолдол эерэг гарсныг тухай бүр нь тусгаарлан эмчлүүлсэн.<br><br>“Санхими”, "Түвшинбилэг төгөлдөр " ХХК -аар ариутгал халдваргүйтгэлийг амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тасаг ХАЯТ, эрчимт эмчилгээ, тусгаарлах өрөө зэрэг бүх нэгжүүдэд нийт 13 удаа хийлгэж 3,426,000 төгрөгийн төсөв гарсан.<br><br><br><br>Коронавирусын халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдлууд үйлчлүүлсэн болон эмч ажилдын дундаас батлагдсан тохиолдол илэрсэнтэй холбогдуулан хэвтэн эмчлүүлэх тасгийн бүх зөөлөн эдлэл дезкамерийн /азонаар/ халдваргүйжүүлэлтийг хийлгэлээ. Давхардсан тоогоор гудас-156, хөнжил-162, матрас том-,26, матрас дунд-228, дэр-72 бүгд 4 нэр төрлийн 644 ш зөөлөн эдлэлийг халдваргүйжүүллээ. Халдваргүйжүүлэлтийн төлбөрт 1,815,400 төгрөгийг төлсөн. |

Коронавируст халдвараас сэргийлж тасаг нэгжүүдэд халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэж байх зорилгоор эрүүл мэндийн төвийн хэмжээнд мананцар үүсгэгч гурван ширхэгийг авсан. Халдваргүйжүүлэлт хийх хуваарийн дагуу тасаг бүр дотооддоо халдваргүйжүүлэлтийг хийж тэмдэглэл хөтлөж байна.









“Нэг хаалга, Нэг шинжилгээ” арга хэмжээг 14 блок хэлбэрээр бүсчлэн 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 08:00-17:00 цагийн хооронд нийт 123 баг, дүүрэг, хорооны ажлын хэсэг, Эрүүл мэндийн төв, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Баянгол дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Баянзүрх дүүргийн баг командаас бүрдсэн мэргэжлийн 921 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр 41256 өрх, иргэнээс тандалт, шинжилгээг хийсэн.





Хан-Уул Эрүүл мэндийн төв, ӨЭМТ-өөс нийт 58 баг 153, Нэгдсэн эмнэлгээс 9, Хан-Туулаас 12 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, Засаг даргын тамгын газар, түүний дэргэдэх албан хэлтсээс 116 ажилтанг явуулын цэгүүдэд ажиллуулж, эрүүл мэндийн шуурхай штаб болон арын албанд ажилтан нийт 222 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр дүүргийн 21 хорооны нийт 42211 иргэн хамруулсан.





Суурин болон явуулын цэгүүдийн байршлын болон зохицуулагч нарын мэдээллийг өдөр бүр Элемент ХХК-д өгч хог хаягдлыг өдөрт 1-2 удаа тээвэрлүүлэн устгуулж ажилласан Үүнд 2-р сарын 11-13-ны өдрүүдэд халдвартай хог хаягдал нийт 356,408 кг-ыг 2-р сарын 18-нд суурин 3 цэгээс явуулын 121 багийн 18 цэгээс нийт 973,5кг хог хаягдлыг тээвэрлүүлэн устгуулсан.





Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн 2020 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс шинжилгээний цэгүүд ажиллаж эхэлсэн бөгөөд түүнээс хойш 2021 оны 11 сарын 20-н хүртэл нийт 256168 иргэн шинжилгээнд хамрагдсан байна.









- Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн үед Коронавируст халдварыг илрүүлэх автобустай явуулын шинжилгээний цэг өдөр бүр 10.00-17.00 цагийн хооронд Буянт–Ухаа Спорт цогцолбор дээр ажиллаж 4-р сарын 10 наас 30 ны хооронд нийт 5011 хүнд, 05-р сарын 01-нээс 05 ны хооронд 806 хүнд , нийт 5817 хүнд коронавирусын халдвар илрүүлэх PCR –ын шинжилгээг хийжээ





- Тандалт шуурхай хариу арга хэмжээний багийг 20 баг 60 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан, үүнээс Эмнэл зүйн 14 багт 42 эмч ажилтан, тандалтын 6 багт 18 эмч ажилтан ажиллаж байна. Байгууллагад суурилсан шинжилгээ -547 хүнээс , давтан шинжилгээ -3046 хүнээс, хавьтлын шинжилгээ-5253 хүнээс авч нийт 8846 шинжилгээг лабораторид хүргүүлжээ
- Хан-Уул дүүрэгт ковид-19 халдварын эсрэг шуурхай хариу арга хэмжээний 16 баг, тандалтын 4 баг 24 цагаар эмнэлзүйн тандалт, хариу арга хэмжээг авч тусламж үйлчилгээг үзүүлэн, хавьталын шинжилгээнд хамруулан, зөвлөгөө өгч ажиллаж байна. 2021 оны 4-8 сард 41-р сургууль дээр 24 цагаар байрлан үйл ажиллагаагаа явуулсан. 2021 оны 9-р сараас Мотобуудлагын спортын төвд шилжин өдөрт 13 баг, 32-төрийн албан алба хаагч, эмч нар ажиллаж байна.
- ШХАХ баг ажилласнаар иргэддээ зөвлөгөө өгөх, эрэмбэлэн ангилж эмнэлэг рүү зөөвөрлөх, яаралтай дуудлаганд шуурхай тусламж үзүүлэх зэрэг Ковид-19 цар тахалтай холбоотой бүхий л үйл ажиллагаанд оролцон үүрэг гүйцэтгэж байна Коронавируст халдвар

11 дүгээр сарын 29-ний байдлаар:

| Нийт батлагдсан тохиолдол | Нас баралт | | Эдгэрсэн | Эмчлэгдэж байгаа | | | Ойрын хавьтал |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сүүлийн 24 цагт | Нийт | | эмнэлэгт | Гэрт | Нийт | |
| 66910 | 0 | 124 | 59916 буюу 89,5% | 1936 | 4531 | 6446 | 5916 |

- ❖ Одоогийг байдлаар батлагдсан 4531 иргэн гэрээр эмчлэгдэж 21 ӨЭМТ-ийн 32 эмч хянаж байна .





"Өлзийт нэг Айдсын даваа" пост дээр 2021 оны 1-р сарын 1-ээс 6-р сарын 22-ны хооронд ЭМТ, 16 хорооны ӨЭМТ, ХУНЭ, тосгоны эмнэлэг, сургууль, цэцэрлэгүүдээс 24 цагаар хуваарийн дагуу эмч сувилагч , резидент эмч нар ажиллаж 97340 тээврийн хэрэгсэл,196366 иргэнд хяналт тандалтыг хийсэн байна Үзлэг тандалтаар халдварын сэжигтэй тохиолдол илрээгүй байна.






ХУД-н НБХэлтэс, МХХэлтэстэй хамтран харьяа 7 их дээд сургуулийн эмч, дотуур байрны эрхлэгч нарт коронавируст халдвараас сэргийлэх, сэжигтэй болон батлагдсан тохиолдлын үед авах арга хэмжээний талаар мэдээлэл, зөвлөгөө өглөө.

Коронавирус халдварт “КОВИД-19” өвчин цар тахлын хэмжээнд хүрч хүүхдүүдийн сургалтыг цахим болон танхимын сургалтыг хослуулах, халдварт өвчин тухайн байгууллагад гарч болох эрсдэлийг тооцох үүднээс 19 сургууль, 29 цэцэрлэгийн эмч нарт сургалт орсон бөгөөд Хан-Уул дүүргийн төрийн 29 цэцэрлэг, 19 сургууль, төрийн бус 92 цэцэрлэг, 28 сургууль нийт 168 хүүхдийн байгууллагын удирдлагуудтай тандалт программд нэвтэрч хавьтал шивэх үйл ажиллагаатай холбоотой нууцын гэрээг 92 цэцэрлэг, 45 сургуулийн захирал, эрхлэгч нартай байгуулж, тандалтын программд нэвтрэх эрх нээж, ажиллах зааварчилгааг өглөө.Сургалтанд дүүргийн улсын сургууль цэцэрлэгүүдийн нийт 46 эмч мэргэжилтэн буюу 97,8% нь хамрагдсан 8-р сарын 31-нд хувийн хэвшлийн сургууль цэцэрлэгийн эмч нарт цахимаар сургалт хийсэн нийт 36 эмч мэргэжилтэн хамрагдлаа. Улс хувийн хэвшлийн нийт 82 эмч мэргэжилтэн хамрагдсан.
Ерөнхий боловсролын 118, 52, 60 дугаар сургуулиудын сургалтын үйл ажиллагааг 7 хоног цахимд шилжүүлж, хичээлийн үйл ажиллагааг танхимд шилжүүлэхээс өмнө боловсролын хэлтэстэй хамтран тус 3 сургуулийн захирал нартай уулзалт хийж, аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа. 52 сургуульд танхимын сургалт эхлэхээс өмнө тус ээлжийн 56 багш ажилчдын ПГУ шинжилгээнд хамруулж 1 тохиолдлыг илрүүлсэн. 60-р сургуулийн 40 багш ажилчдыг шинжилгээнд хамруулаад байна.Сургууль цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа эхлэж хүүхдийн байгууллагуудад халдварын тохиолдол гарч байгаатай холбогдуулан хүүхдийн байгууллагуудын өвчлөл, хавьтлуудын мэдээллийг нэгтгэн авч дүгнэлт хийж, эмч нарыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах мэргэжилтнийг томилон ажиллуулж, 2021.09.09-нд ХУЭМТ нь дүүргийн боловсролын хэлтэстэй хамтран ХУД нь төрийн 29 цэцэрлэг, 19 сургууль, төрийн бус 92 цэцэрлэг, 28 сургууль нийт 168 хүүхдийн байгууллагын удирдлагуудтай тандалт программд нэвтэрч хавьтал шивэх үйл ажиллагаатай холбоотой нууцын гэрээг 92 цэцэрлэг, 45 сургуулийн захирал, эрхлэгч, нийт 137хүүхдийн байгууллагатай гэрээ байгуулж, тандалтын программд нэвтрэх эрх нээж, ажиллах зааварчилгааг өглөө.






**Дархлаажуулалтын үйл ажиллагаа:**

Дүүргийн хэмжээнд Ковидын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж дархлаажуулалтын 19 түр цэгийн урсгал зохион байгуулалтыг хийж мэргэжил арга зүйгээр ханган үйл ажиллагааны явцад дэмжлэгт хяналт тандалтыг хийн ажиллаж байна





Байнгын 19 цэг дээр ӨЭМТ болон ЭМТ-ийн эмч ажилтан, резидэнт эмч нараас бүрдсэн 166 хүний бүрэлдэхүүнтэй баг, дархлаажуулалтын төлөвлөлт хангалтын 9 хүний бүрэлдэхүүнтэй баг, явуулын 3 автобусны 24 хүний бүрэлдэхүүнтэй баг нийт 199 эмнэлгийн эмч, ажилтнууд ажилласан байна.





Коронавируст халдварын эсрэг нэмэлт тун буюу 3 дахь тунгийн хамрагдалтыг эрчимжүүлэх зорилгоор аж ахуй нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдыг нэмэлт тунгаар дархлаажуулах байнгын, түр явуулын цэгийг нээж дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх зохион байгуулалтыг хийж байна .







Дархлаажуулалтын үйл ажиллагаа эхэлснээс хойш 2021.02.23-аас 398574 хүнийг 1,2,3-р тунгаар дархлаажуулаад байна. Үүнээс 1-р тунд-177424 /132,9% ,2-р тунд-175325/ 131,3%/, 3-р тунд- 45825/34%/-ийг хүнийг тус тус дархлаажуулаад байна.

ЭМТ-ийн нийт эмч ажилчдын 87,4% нь астразеника , 6,0% веросел, 3,3% спутник, 3,3% фрайзр вакцины 1,2-р тунгаар дархлаажуулагдсан ба нэмэлт тун буюу 3-р тунд 61,3% нь астразеника,38,7% фрайзр вакцинд хамрагдсан байна.

| Нийт эмч ажилчдын тоо | Вакцины хамралт | | | Дархлаажуулалтад хамрагдаагүй шалтгаан | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1-р тунд | 2-р тунд | 3-р тунд | Өвчний заалтаар | жирэмсэн | Өөрөө татгалзсан |
| 217 | 211/97,2%/ | 211/100%/ | 125/59,2%/ | 3 | 0 | 3 |




ДЭМБ-ын санхүүжилтээр **К**овид-19 цар тахлын эсрэг ХУД-н хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх нь төслийн хүрээнд 10 сарын 25-аас 11-р сарын 4-ний хооронд зохион байгуулагдсан сургалтанд суусан эмч эмнэлгийн ажилтнуудад Коронавируст халдварын сэргийлэлт, эрүүл мэндийн ажилчдын өвчлөлийн өнөөгийн байдал, стандарт сэргийлэлт, хамгаалах хувцас хэрэгслийн зөв өмсөж тайлах чиглэлээр сургалт дадлагыг хийж нийт 96 эмч эмнэлгийн ажилтныг хамрууллаа.





2021 оны 11-р сарын 18- -нд Коронавируст халдварын эмчилгээ оношлогоо тандалтын чиглэлээр ӨЭМТ -үүдийн эмч нарт ХӨСҮТ -с нэг өдрийн танхимын сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтанд нийт 16 эмч хамрагдлаа.




Үйлчлүүлэгчдэд ковидтой холбоотой 56 төрлийн сэдвээр 97 удаагийн мэдээлэл зөвлөгөөг цахимаар иргэдэд хүргэж ажилласан ба нийт 47325 иргэн хандалт хийж үзсэн байна. Амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасгаар үйлчлүүлж буй бүх үйлчлүүлэгчдийг амны хаалттай үйлчлүүлж байна. Амны хаалтыг хэрхэн зөв хэрэглэх амны хаалтыг заавал зүүж байх талаар иргэдэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны материал зурагт хуудсуудыг ил тод байршуулан мэдээлэл сурталчилгааг явуулж байна.






Иргэд хоорондын зайгаа барих 12 ширхэг тэмдэг тэмдэглэгээг байршуулж, Халдвар хамгааллын дэглэм барин үйлчлэх зөвлөмжийг хадсан бөгөөд мөн дуугүй хөтчүүдийг байршуулан ажиллаж байна.







ДЭМБ-ын санхүүжилтээр Ковид-19 цар тахлын эсрэг ХУД-н хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх нь төслийн хүрээнд 10 сарын 25-аас 11-р сарын 4-ний хооронд зохион байгуулагдсан сургалтанд суусан эмч эмнэлгийн ажилтнуудад Коронавируст халдварын сэргийлэлт, эрүүл мэндийн ажилчдын өвчлөлийн өнөөгийн байдал, стандарт сэргийлэлт, хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөж тайлах чиглэлээр сургалт дадлагыг хийж нийт 96 эмч эмнэлгийн ажилтныг хамрууллаа.





2021 оны 11-р сарын 18-нд Коронавируст халдварын эмчилгээ оношлогоо тандалтын чиглэлээр ӨЭМТ -үүдийн эмч нарт ХӨСҮТ - өөс нэг өдрийн танхимын сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтанд нийт 16 эмч хамрагдсан.




Үйлчлүүлэгчдэд ковидтой холбоотой 56 төрлийн сэдвээр 97 удаагийн мэдээлэл зөвлөгөөг цахимаар иргэдэд хүргэж ажилласан ба нийт 47325 иргэн хандалт хийж үзсэн байна. Амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасгаар үйлчлүүлж буй бүх үйлчлүүлэгчдийг амны хаалттай үйлчлүүлж байна. Амны хаалтыг хэрхэн зөв хэрэглэх амны хаалтыг заавал зүүж байх талаар иргэдэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны материал зурагт хуудсуудыг ил тод байршуулан мэдээлэл сурталчилгааг явуулж байна






Иргэд хоорондын зайгаа барих 12 ширхэг тэмдэг тэмдэглэгээг байршуулж, Халдвар хамгааллын дэглэм барин үйлчлэх зөвлөмжийг хадсан бөгөөд мөн дуугүй хөтчүүдийг байршуулан ажиллаж байна







- Эхний 10 сарын байдлаар ДОХ/БЗДХӨ-ний кабинетаар урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 2895 иргэн хамрагдсанаас 13 өвчлөлийг эрт илрүүлж 100 хувь эмчилгээнд харуулсан.
- “Тэнэмэл иргэд” арга хэмжээг ДОХ/БЗДХӨ-ний кабинетийн эмч, сүрьеэгийн диспансерийн эмч нар, Цагдаагийн хэлтэс, улаан загалмайн хороо, ӨЭМТ-үүдтэй хамтран 2 удаа үзлэгийг зохион байгуулж 80 гаруй иргэнийг хамруулаад байна.
- ЭМС-ын 2017 оны А/145 дугаар тушаалаар Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 12,000 хүнийг үзлэгт хамруулсан. Үүнээс Төрийн болон хувийн хэвшилийн ЕБС, цэцэрлэгийн 3082 багш ажилчдыг үзлэгт хамруулж, хоёр идэвхтэй хэлбэрийн сүрьеэг илрүүлж хяналтанд авч, эмчилж байна.
- Дүүргийн цагдаагийн 1,2-р хэлтсийн 156 алба хаагчийг ДОХ/БЗДХӨ, сүрьеэ илрүүлэх үзлэгт хамруулж шинэ тэмбүү -1 илрүүлж эмчилгээнд хамруулсан.
- Их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутаны үзлэг хийгдэж байна. Одоогийн байдлаар 400 гаруй оюутныг хамруулаад байна.

- ❖ Сүрьеэгийн диспансерийн үзлэг 2021 оны 10 дугаар сарын байдлаар 5066 хүнд амбулаторийн үзлэг хийж шинээр илэрсэн уушгины сүрьеэ өвчтэй 305, эмэнд мэдрэг сүрьеэтэй өвчтөн 269, эмэнд тэсвэртэй өвчтөн 36 хүн эмчийн хяналтанд хянагдаж байна.
- ❖ Үүнээс урьдчилан сэргийлэх эмчилгээнд 17, диспансерт 39, онлайн хяналтаар 14, ӨЭМТ-12 Сайн дурын идэвхтэн 38, СКЭ хэвтэж байгаа 3 хүн байна. ЭТС диспансерт тогтмол ирж эмээ ууж байна.

Заавал хийх дархлаажуулалтын хамралтын мэдээ, тархвар судлалын заалт, нөхөн дархлаажуулалтын хамралтын мэдээ, вакцины орлого зарлагын мэдээг цаг хугацаанд нь гаргаж дүгнэлт хийн ажиллаж байна.

**ВАКЦИНЖУУЛАЛТЫН ХАМРАЛТ:** Товлолт дархлаажуулалт 2021 оны эхний 10 сараар /бүрэн тунгаар/

| Вакцины нэр | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Хувь |
|---|---|---|---|
| Тавт3 Саа4 | 4543 | 4527 | 99,6% |
| УГУ1 | 4318 | 4307 | 99,7% |
| Агепатит1 | 3735 | 3727 | 99.7% |
| УГУ2, Агепатит2 | 3405 | 3366 | 98.8% |
| ПЭВ3 | 4252 | 4241 | 99.7% |
| Саа5 | 4410 | 4395 | 99.6% |
| Сахуу, татран | 4479 | 4256 | 95% |
| **Бүгд** | 29142 | 28819 | 98.8% |

**Нөхөн дархлаажуулалт:**

2021 оны эхний 10 сарын байдлаар товлолын дархлаажуулалтаас хоцорсон хүүхдүүдийг ЭМС-ын 261 дугаар тушаалын дагуу нөхөн дархлаажуулалтанд хамруулах ажлыг зохион байгуулж Сүрьеэгийн вакцинд - 8, Тавт, саа-2548, УГУ -948,А гепатит-748, ПЭВ-1562 хүүхдийг тус тус хамруулсан байна

**Тархвар судлалын дархлаажуулалт:**

- ❖ Галзуугийн вакцинд-965 хүн/тун вакциныг 350 хүнд хийсэн бөгөөд бүрэн тунгаар хамрагдалт 94.6% байна. Үүнээс: 0-1 насны 4, 2-4 насны 27, 5-15 насны 117, 16-19 насны 22, 20-44 насны 85, 45-64 насны 79, 65-75 насны 16 хүн байна.
- ❖ В гепатит – ЭМТ болон ӨЭМТ-ийн эмч, ажилчдыг В гепатитын эсрэг вакцинд хамруулах ажлыг зохион байгуулж байна. 2021 оны 10 сарын байдлаар нийт 68 хүн/тун вакциныг эмч, эмнэлгийн ажилчдад хийсэн байна.

| | I тун | II тун | III тун |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| ХУЭМТ | 3 | 3 | 7 |
| ӨЭМТ | 27 | 18 | 10 |
| **Нийт** | **30** | **21** | **17** |

Сургалт сурталчилгаа:

1.Ковид -19 цар тахлын хөл хориотой холбоотойгоор сургалт сурталчилгааг интернет ашиглаж zoom- ээр ӨЭМТ-ын эмч нар болон Эх барих эмэгтэйчүүдийн эмч нарт 2 удаа АШУИС-ийн халдварт өвчний тэнхим болон ХӨСҮТ –ийн БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тандалт судалгааны албатай хамтран явуулсан.Тус сургалтанд нийт 15 ӨЭМТ болон 1 тосгоны эрүүл мэндийн төвийн НҮЭМ хариуцсан эмч -16, халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр хариуцсан эмч- 16 , эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нийт -8, нийт 40 эмч мэргэжилтэнүүд хамрагдсан

2. ХӨСҮТ-ийн БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тандалт судалгааны албанаас ӨЭМТ-ийн болон нарийн мэргэжлийн эмч нарт зориулсан 1."БЗДХ,ХДХВ,ДОХ-ын тусламж үйлчилгээ", “Эхээс хүүхдэд ХДХВ,тэмбүү, гепатит В вирусийн халдвар дамжихаас сэргийлэх нь" зайн сургалтанд нийт 50 эмч сувилагч эх баригч хамрагдсан.

3.”TORCH шинжилгээ түүний ач холбогдол, “Микоплазмын халдвар” сургалтыг онлайнаар БЗДХ/ХДХВ/ДОХ-ын зохицуулагч эмч ӨЭМТ-ийн 70 эмчид сургалт хийсэн.

4. Эмнэлзүй, оношилгоо, эмчилгээний чиглэлээр давхардсан тоогоор 115 эмч, сувилагч нарыг цахим сургалтанд 4-5 удаа хамруулсан. Нийт ажилчдын судалгааг гаргаж хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээ хийж, дутагдалтай орон тоон дээр ажиллуулах эмч, сувиалгч нарыг ЭМЯ, Этүгэн дээд сургуулиас гэрээгээр резидент эмч, сувилахуйн төгсөх курсын оюутануудыг дайчлан ажиллуулж байна. Эмч, ажилчдын дунд Арт терапи буюу зургаар сэтгэл засал, бүлгийн сэтгэл заслыг тасаг нэгж тус бүрээр зохион байгуулсан мөн ажлаас халширах хам шинжийн судалгаа ажилчдын дунд хийж дүгнэсэн. “Стресс менежмент” цахим сургалтыг АШУҮИС-аас, Ёс зүй ,харилцааны ур чадвар сэдвээр “Ур чадварын-Хүрээлэн” ТББ-аас 80 эмч, ажилчдад танхимын сургалтыг тус тус зохион байгуулсан.

| | | |
|---|---|---|
| 2 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа төлөвлөж зохион байгуулсан байдал. Нийслэли | **Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, салбар дундын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилтын хүрээнд:**<br><br>1. ДЭМБ-ын санхүүжилтээр **К**овид-19 цар тахлын эсрэг ХУД-н хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх нь төслийн хүрээнд 10 сарын 25-аас 11-р сарын 4-ний хооронд зохион байгуулагдсан сургалтанд суусан эмч эмнэлгийн ажилтнуудад Коронавирусt халдварын сэргийлэлт, эрүүл мэндийн ажилчдын өвчлөлийн өнөөгийн байдал, стандарт сэргийлэлт, хамгаалах хувцас хэрэгслийн зөв өмсөж тайлах чиглэлээр сургалт дадлагыг хийж нийт 96 эмч эмнэлгийн ажилтныг хамрууллаа.<br>  <br>❖ Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв нь шаардлагатай тоног төхөөрөмжийн санал, хүсэлтийг дээд шатны байгууллагуудад тогтмол санал тавьж шийдвэрлүүлсэн байна. 2021 онд 63 нэр төрлийн 1.817.731.540 төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.<br>❖ Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 21 нэр төрлийн 69.206.100 төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшил нийлүүлж, байгууллагын өөрийн хөрөнгөөр 1.340.000 төгрөгийн 3 нэр төрлийн тоног төхөөрөмж, 21.065.000 төгрөгийн үнэ бүхий 19 нэр төрлийн тавилга эд хогшил худалдан авсан.<br>❖ Коронавирусt /COVID-19/ халдварын өвчлөл нэмэгдсэнтэй холбогдуулан ЭМЯ-ны шийдвэрээр Туул тосгоны эмнэлгийн шинэ байранд дүүрэг болон өөрийн хөрөнгө оруулалтаар шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгсэлүүдээр хангаж тусламж үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг хангасан.Туул 100 ортой тусгаарлах эмнэлгийг 2021 оны 06 дугаар сарын 23-аас нээн ажиллуулж 2021 оны 06 дугаар сараас 11 дүгээр сарын 20-ны хооронд нийт 1536 хүнийг хэвтүүлэн эмчилж, ЭМЯ-ны шийдвэрээр 11 дүгээр сарын 27-нд үйл ажиллагааг зогсоосон. |

<table>
<tr>
<td></td>
<td>йн төсөв, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажпын гүйцэтгэл, чанар, үр дүн</td>
<td>




Байгууллагын өөрийн төсөв хөрөнгөөр хийгдсэн засвар үйлчилгээ:

❖ Эрүүл мэндийн төвийн хүлээн авах тасагт их засвар хийж, гадна үүдний ханыг будаж, вакум хаалтыг хийж, гаднах шатыг налуу болгон цементжүүлэн зассан. Хүлээн авах тасгийн ханыг ламинатороор бүрж, хаалга шалны хулдаасыг сольсон.





❖ Гэмтлийн цэвэр бохир боолтны өрөө, ажилчдын ариун цэврийн өрөө, өдрийн эмчилгээний өрөө, үйлчлүүлэгчийн хувцасны өлгүүрийн өрөөг засварлаж тохижуулсан. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд халаалт муу, төгсгөлийн паарнуудад халаалт очдоггүй, өвөлдөө их хүйтэн байдаг байсан тул сантехникийн инженер, слесариудтай зөвлөлдөж, халаалтын эргэлтийн насос авч, эрүүл мэндийн төвийн узелийн өрөөний буцах шугамыг тайрч, өндөр даралтын гагнуурчнаар насосоо гагнуулж бэхэлсэн.Ингэснээр эргэлтийн хурд нэмэгдэж, халаалт сайжирсан.




</td>
</tr>
</table>

- Эрүүл мэндийн төвийн 3 давхарын Б, В корпусын коридорт иж бүрэн засвар хийж 20 кабинетийн хаалга сольж, шалны хулдаасыг бүрэн шинэчлсэн.







| | | |
|---|---|---|
| 3 | Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийсэн ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн | **Иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт жилд нэг удаа үнэ төлбөргүй хамруулах, өвчнийг хянах цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.**<br><br>❖ **2021 оны эхний 10сарын байдлаар:**<br>Дүүргийн зорилтот бүлгийн 118527хүн амаас АГ-ын эрт илрүүлэг үзлэгт 74325 хүн хамрагдаж 62,7%-тай байна. Үүнээс: эрэгтэй -32502, эмэгтэй 41823<br>АГ- шинээр оношлогдсон 52 хүнийг эмчийн хяналтанд авч, давтан үзлэгт 13562 хүн орж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.<br>Чихрийн шижин хэв шинж -2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа 60381 хүн хамрагдаж 50,9 %-тай байна. Үүнээс: эрэгтэй -26627, эмэгтэй -33754, шинээр оношлогдсон 6 хүнийг эмчийн хяналтанд авч, давтан үзлэгт 4376 хүн орсон байна.<br>❖ Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт нийт 10380 эмэгтэй хамрагдахаас эхний 11 сарын байдлаар 2642 эмэгтэй хамрагдаж 25 %-тай хамрагдсан байна.<br>❖ Хөхний хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт 46519 эмэгтэй хамрагдахаас эхний 11 сарын байдлаар 28469 эмэгтэй хамрагдаж 61% -тай байна.<br>❖ Хөхний хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт 46519 эмэгтэй хамрагдахаас эхний 11 сарын байдлаар 25300 эмэгтэй хамрагдаж 55% -тай байна.<br>❖ Дотоод үйл ажиллагаанд 1 жилийн баталгаажуулсан эрхтэй Zoom програм хангамжийг ашиглаж байна.<br>   |
| Хоёр: Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн | | |
| 1 | Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт буюу байгуулл | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 395 дугаар тогтоол, Хан-Уул эрүүл мэндийн төвийн удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн төвийн даргын 2020-04-01-ний өдрийн А29 тоот “Эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад үр дүнгийн урамшуулал олгох журам батлах тухай ”тушаалыг батлан хэрэгжүүлж байна. 2021 оны 1-р улирлын байдлаар 221 ажилтанд үр дүнгийн урамшуулалаар 45.847.813 төгрөг, 2021 оны 2 дугаар улирлын байдлаар 220 ажилтанд үр дүнгийн урамшуулалаар 54.186.292 төгрөг, 3 дугаар улирлын байдлаар 217 ажилтанд үр дүнгийн урамшуулалаар 60.867.422 төгрөг бүгд 160.901.527 төгрөгийг тус тус олгосон байна<br>Тус эрүүл мэндийн төвөөс: |

| | | |
|---|---|---|
| | агын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /КР1/-ээр үнэлсэн үнэлгээний дүн | • Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор -2<br>• Алтан гадас одонгоор -7<br>• Хөдөлмөрийн хүндэт медаль-6<br>• Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан цол тэмдгээр -15<br>• ЭМЯамны –Жуух бичгээр -3<br>Нийслэл, дүүргийн бусад шагналд – 12 хүн шагнууллаа<br>Коронавирусын халдварын хяналт, сэргийлэлт, бэлэн байдал дэгдэлтийн үед ажиллах хариу арга хэмжээг эрчимжүүлэх ажлын хүрээнд ЭМТөвийн даргийн 2021 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/03 дугаар тушаалыг гарган 4 чиглэлээр 23 заалт бүхий  төлөвлөгөө, COVID-19”халдварын үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөөндөө тодотгол хийж 2 чиглэлээр 22 заалт бүхий төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн Коронавирусийн халдварын талаар ЭМЯ, ХӨСҮТ, нийслэл дүүргийн тамгын газар , НЭМГ-аас ирүүлж буй тушаал, захирамж , заавар зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр ЭМТ-ийн даргын нийт 4 тушаал, 18 заавар журмыг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна<br>Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, ор дэлгэх төлөвлөгөөний дагуу 7 орыг бэлтгэсэн.<br>  <br>215 нэр төрлийн эм тариа, 89 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 237 тоног төхөөрөмжийн судалгааг гаргалаа.<br>Тусгаарлах өрөөг 2 ортойгоор  стандарт шаардлагын дагуу урсгалыг зохион байгуулан бүс бүрт байх шаардлагатай багаж тоног төхөөрөмж хэрэгслүүдийг тус тусд нь байршуулж бэлэн байдлыг хангаж ажиллаж нийт 28 сэжигтэй тохиолдлыг тусгаарлан онош батлагдсан.25 тохиолдлыг зөөвөрлөн тусгаарлуулж эмчлүүлсэн |

  

Тусгаарлах хэсгийн шар, улаан бүсэд шинээр нэмж камер байршуулж,тусламж үйлчилгээ, халдвар хамгааллын дэглэм, хамгаалах хувцас хэрэгслийг зөв тайлж байгаа эсэхэд тухай бүр нь ЭЭО даргын өрөөнөөс хянаж байна.

 

Байгууллагынхаа QR кодыг хэвлэн амбулатори, хүлээн авах хэсэгийн орох хаалганы дэргэд байршуулан хөтөч сувилагч үйлчлүүлэгчид QR кодыг уншуулахыг зөвлөн уншуулж халууныг үзэж байгаа ба QR кодоо уншуулах боломжгүй иргэдийг тусгай бүртгэлийн журналд бүртгэн оруулж байна.

Хан-Уул эрүүл мэндийн төвийн 3 салбар амбулатори бүрт халуун хэмжиж, гар ариутган QR код уншуулж үйлчлүүлсэн нийт **783108** иргэн байна.

- Халуун хэмжигч – суурин 3, зөөврийн 25
- Гар ариутгах шингэн – 150л

- QR код – 30 ш

  

“Ковид 19” халдвартай өвчтөнийг эрт илрүүлэх зорилгоор амьсгалын замын өвчний шинж тэмдэгтэй өвчтөний үзлэгийн өрөөг 1 давхарт зохион байгуулан ажиллуулж байна. Ажиллах эмч нарын хуваарийг гаргаж батлуулж тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

 

Коронавирусын халдвараас сэргийлэх халдварын голомтыг таслан зогсоох зорилгоор хэвтэн эмчлүүлэх тасаг, төв болон яармаг салбар амбулаторийн бүх тасаг нэгжүүдэд урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг Ариутгал халдваргүйтгэлийн “Түвшинбилэг төгөлдөр” , Санхими ХХК-д захиалга өгч нийт 6 удаа халдваргүйжүүлэлтийг хийлгэж тус халдваргүйжүүлэлтийн төлбөрт нийт 1,800,000 төгрөгийг зарцуулсан.

  

Хан-Уул дүүргийн хэмжээнд “Нэг хаалга, Нэг шинжилгээ” арга хэмжээг 14 блок хэлбэрээр бүсчлэн 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 08-9:00-17:00 цагийн хооронд нийт 123 баг, Дүүрэг, хорооны ажлын хэсэг, Эрүүл мэндийн төв, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Баянгол дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Баянзүрх дүүргийн баг камандаас бүрдсэн мэргэжлийн 921 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр амжилттай зохион байгууллаа.

Хан-Уул Эрүүл мэндийн төв, ӨЭМТ-өөс нийт 58 баг 153, Нэгдсэн эмнэлгээс 9, Хан-Туулаас 12 эмч, сувилагч, эмнэлгийн








мэргэжилтэн, Засаг даргын тамгын газар, түүний дэргэдэх албан хэлтсээс 116 ажилтанг явуулын цэгүүдэд ажиллуулж, эрүүл мэндийн шуурхай штаб болон арын албанд ажилтан нийт 222 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр тус арга хэмжээнд оролцлоо Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн 2020 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс шинжилгээний цэгүүд ажиллаж эхэлсэн бөгөөд түүнээс хойш 2021 оны 11 дүгээр сарын 25-н хүртэл нийт 256168 иргэн шинжилгээнд хамрагдсан байна.

**Дархлаажуулалтын үйл ажиллагаа**

Коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулж Эрүүл мэндийн сайдын 2021 оны 108,119-р тушаалаар:

- 2 сарын 23-нд вакцин 1 цэгт ХУЭМТөвийн нэг баг 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж эхэлсэн.
- 3 сарын 9-нээс байнгын 4, түр цэг 4 байгуулагдан 64 эмч тусгай мэргэжилтний бүрэлдэхүүнтэй ажилласан.
- 4 сарын 4 эхлэн байнгын 9 цэгээр 120 эмч тусгай мэргэжилтний бүрэлдэхүүнтэй ажилласан.
- 4 сарын 9-нээс хөл хориотой холбоогдуулан эрүүл мэндийн 4,5-р бүлгийн ахмад настанд 1 цэгээр дархлаажуулалт хийсэн.
- 4 сарын 19-нээс байнгын 3, түр 1 цэгээр ажилласан.
- 4 сарын 23-наас байнгын 19, явуулын 3 багийн нийт 166 эмч, эрүүл мэндийн ажилтан ковидын эсрэг дархлаажуулалт хийсэн.
- 5 сарын10-наас байнгын 11 цэг ажиллаж эхэлсэн.

- 5 сарын 12-наас байнгын 6 баг явуулын 1 баг ажиллаж байгаад 6 сарын 12-наас байнгын 4 цэгт 28 эмч, эрүүл мэндийн ажилтаны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

ХӨСҮТөвөөс “АстраЗенека-Оксфорд”-ын 20700 хүн тун, shiopram үйлдвэрийн Verocell 237532, спутник-2000, файзер-1884 нийт 262116 хүн тун вакцин хүлээн авсан

